

# АХМАД НАСТАНД НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ОНЦЛОГ

*Н.Оюут-Эрдэнэ  
Нийгмийн ажлын магистр*

Нийгмийн ажлын үйлчилгээний нэг чиглэл нь ахмад настанд үзүүлэх халамж үйлчилгээ юм. Дэлхийн 65 болон түүнээс дээш настай хүмүүсийн тоо 1990 онд 357 сая байснаа 2025 онд 761 сая хүртэл өсөхөөр тооцоологдож байна. Ингэснээр дэлхийн хүн амын долоон хүн тутмын нэг нь 65-аас дээш насны хүн болох юм. Одоогийн байдлаар хөгжиж буй орнуудад бүх ахмад настнуудын 60 хувь нь амьдарч байгаа бөгөөд 2025 онд 75 хувь болох ажээ. Ялангуяа 75-аас дээш насны хүмүүсийн тоо түргэн хурдацтай өсөж байна. Монгол улсын хүн ам 2005 оны байдлаар залуу хүн амын бүтэцтэй тооцогдож байгаа билээ. Өөрөөр хэлбэл нийт хүн амын 70 хувь нь 35-аас доош насны хүүхэд залуучуудаас бүрдэж байна. Энэ онцлогтой уялдан Монгол улсад хүүхэд залуучуудын асуудлаар ажилладаг, тэдэнд үйлчилгээ үзүүлдэг нэлээд тооны нийгмийн үйлчилгээний байгууллагууд байдаг. 2004 оны жилийн эцсийн байдлаар Монголын хүн амд жараас дээш насны хүмүүсийн эзлэх хувийн жин 5,2 хувиас хэтрэхгүй байна. Гэхдээ ахмад настны бүлгийн тоо хэмжээ түргэн хурдацтай өсч 2020 он гэхэд хүн амын 10 хувь болох тооцоо гарчээ.

Ахмад настанд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд ерөнхий арга зүйг ашиглахаас гадна тусгай мэдлэг чадварт тулгуурлан үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ байдаг. Энэхүү тусгай мэдлэг чадвар нь ахмад настнуудын бие физиологи, сэтгэл зүй, аж байдал, танин мэдэхүй, тэдний эрүүл мэнд, нийгмийн үүрэг харилцааны өөрчлөлт, онцлогуудтай холбоотой. Ахмад настнуудтай ажиллахдаа ганцаарчилсан үйлчилгээ үзүүлэх, бүлгээр болон гэр бүлтэй нь ажиллах зэрэг арга зүйг ашиглана. Мөн ахмад настны нөхцөл байдлын талаар судалгаа хийх, олон нийтэд насжилтын талаар шинжлэх ухааны мэдлэг ойлголт буюу геронтологийн боловсрол олгох, ахмад настны асуудлаарх бодлогод нөлөөлөх, сургалт сурталчилгаа явуулах зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх хэрэгцээтэй.

Нийгмийн ажлын микро түвшний үйлчилгээ нь үйлчлүүлэгчтэй шууд тулж ажиллах хэлбэр буюу хувь хүнтэй ганцаарчлан ажиллах, гэр бүл, жижиг бүлэгтэй ажиллах арга хэлбэрийг хамруулдаг.

Үйлчлүүлэгчтэй холбоо тогтоох буюу нийгмийн ажлын үйлчилгээний харилцаа тогтоох нь Ахмадуудын амьдралд тэдний насны амьдралын мөчлөгөөс шалтгаалан олон өөрчлөлтүүд явагддаг билээ. Жишээ нь тэтгэвэрт гарах, хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн буюу их хэмжээгээр алдах, өвчин тусах, хань ижил, найз нөхдөөсөө хагацах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжгүй болох гэх мэт өөрчлөлтүүд гардаг. Тиймээс ахмад настнуудын дунд ганц бие, бусдаас тусгаарлагдмал амьдардаг хүмүүс олон бий. Тэдэнтэй нийгмийн ажилтан холбоо тогтооход амархан байж болно. Учир нь тэд хүмүүстэй сэтгэл санаагаа хуваалцах, яриа хөөрөө дэлгэх хэрэгцээ их учраас ямар ч хүнийг таатайгаар нээлттэй хүлээн авдаг талтай. Гэхдээ энэ нь нийгмийн ажилтан тухайн үйлчлүүлэгчтэй нийгмийн ажлын үйлчилгээний харилцаа тогтоолоо гэсэн үг биш юм. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгч хоёрын хооронд жинхэнэ харилцаа нь итгэлцэл тогтож, үйлчилгээний талаар хэлэлцэхээс эхэлнэ.

Энд анхаарах өөр нэг асуудал нь үйлчлүүлэгчийн бие махбодын буюу хөдөлгөөн, үйл ажиллагааны чадвар, сонсох, харах, сэтгэн бодож хүлээж авах чадварын түвшинг харгалзах явдал байдаг. Нийгмийн ажилтан өөрийгөө сайн танилцуулах, үйлчлүүлэгчтэй харилцахдаа тод, чанга, ойлгомжтой ярих хэрэгтэй. Хурдан ярьснаас, эсвэл олон зүйлийг нэг дор тайлбарласнаас, эсвэл сонсогдохгүйгээс болоод үйлчлүүлэгч таны хэлснийг ойлгохгүй дахин асууж лавлах байдал гарна.

Асуудлыг тодруулж судлах нь

Үйлчлүүлэгчид тулгамдаад байгаа асуудлыг тодруулах гэдэг нь түүнийг нарийвчлан судалж холбогдох хүчин зүйлүүдийг тодорхойлох явц байдаг. Нийгмийн ажилтны хувьд үйлчлүүлэгчид аль болох мэдрэмжтэй хандаж мэдээллийг дэлгэрэнгүй олж авах хэрэгцээ тулгарна. Бусад насны

үйлчлүүлэгчийг бодвол ахмад настангууд илүү их дэлгэрэнгүй мэдээлэл өгөх хандлагатай. Иймд гол тулгамдаад байгаа асуудлыг нь тодруулах нь чухал болно. Ялангуяа тэд хэрхэн амьдарч байгаа, бусдаас хамаарах байдал хэр байгаа, эрүүл мэндийн хувьд болон хүмүүстэй харилцах харилцаа нь ямар байгаа, нийгмийн амьдралаас хэр тусгаарлагдсан, хэн нэгнээ алдсан эсэх зэрэг мэдээллийг тодруулах хэрэгтэй болдог. Жишээ нь, нийгмийн ажилтанд үйлчлүүлэгч настан нь “Би хүүхдүүддээ дараа болохыг хүсэхгүй байна” гэж хэллээ. Нийгмийн ажилтан үүнд хэрхэн хандах вэ? Юуны өмнө түүний ингэж хэлсэн нь ямар утга санаатай болохыг үйлчлүүлэгчээс асууж тодруулах хэрэгтэй болно. Ингэснээр ямар хүчин зүйл нөлөөлсний улмаас үйлчлүүлэгч ингэж хэлснийг ойлгох алхам хийгдэнэ.

Ахмад настантай ажиллахад түгээмэл ашиглагддаг арга зүй бол тэдний амьдралын түүхийг сонсох явдал байдаг. Амьдралын түүхээсээ ярих явцад нь тэдний давуу болон сул тал, мэдлэг чадварын түвшин, үзэл хандлага зэргийг ойлгож мэдэх бололцоотой. Өнгөрсөн амьдралдаа ямар байсан талаарх үйлчлүүлэгчийн ярианд тулгуурлан өнөөгийн байдлаар тэдний дасан зохицох болон аливаа бэрхшээлийг даван туулахад тус болох ямар хүчин зүйл байгааг олж харах боломжтой. Тэдний ярианаас нийгмийн ажилтан өөрийн ажилд ашиглагдах мэдээллийг соргоогоор олж авах чадварт суралцах хэрэгтэй болно. Жишээ нь нийгмийн ажилтанд нэгэн ахмад настан нэг л түүхийг уулзах болгондоо байнга ярьдаг байжээ. Тэрээр үйлдвэрийн хэлтсийн дарга байж олон хүнийг удирддаг байсан тухайгаа олон удаа ярьсныг нийгмийн ажилтан анхаарч лавлахгүйгээр үйлчлүүлэгчид тулгамдсан бусад асуудлыг хэлэлцэхийг оролдож байв. Гэхдээ бусад нийгмийн ажилтантай зөвлөлдсөний үр дүнд тухайн үйлчлүүлэгч өөрийгөө дандаа ийм сул дорой байгаагүй гэдгээ харуулах санаатай байгааг анхаарч санал бодлоо хуваалцах хэрэгцээ байгааг олж харж энэ тухай ярилцаж чаджээ. Тэгэхээр үйлчлүүлэгчийн хэрэгцээг тэдний байр сууринаас олж харж асуудлыг шийдвэрлэх шаардлагатай нь илэрхий байна. Ихэнх тохиолдолд ахмад настны тулгамдсан асуудал нь бодит, материаллаг туслалцааг шаардаж байдаг гэсэн өрөөсгөл ойлголт нийгмийн ажлын мэргэжилтнүүдэд байдаг байна. Гэтэл ахмадуудын асуудал нь нарийн төвөгтэй, олон талын, өргөн хүрээтэй байдаг.

Ахмад настангуудтай ажиллахад хувь хүний үзэл бодол нөлөөлж ёс зүйн хоёрдмол байдал тулгарч болно. Тухайлбал ахмадын үгийг сөрөх ёсгүй, тэдний үгийг хууль мэт дагах хэрэгтэй, ахмадуудыг хүндэтгэх үүрэгтэй гэх мэт уламжлал ёс заншил байдаг. Гэтэл нийгмийн ажлын мэргэжилтнүүд ахмад настан үйлчлүүлэгчид тулгарсан асуудлыг асууж лавлаж байж тодорхойлох хэрэгцээтэй байдаг. Нийгмийн ажил нь мэргэжлийн харилцаа учраас шаардлагатай мэдээллийг ахмадуудаас сайн асууж лавлаж байж олж авна гэдгийг нийгмийн ажилтан ойлгож, хувийн хандлагаасаа мэргэжлийн харилцааг ялгаж салгаж авч үзэх хэрэгтэй болно. Нөгөөтэйгүүр, ахмад настангуудтай ажиллахдаа бусад үйлчлүүлэгчтэй ажилладгийн нэгэн адил тэдний үйл хөдлөл, хэлсэн санаа, зан үйлийн давтамжийг ажиглаж асуудлыг тодруулах сэжиг болох мэдээллийг олж авах бололцоог ашиглах шаардлагатай.

Нөхцөл байдлын үнэлгээ ба үйлчилгээг төлөвлөх нь

Нөхцөл байдлын үнэлгээ хийх нь нийгмийн ажлын үйлчилгээний үндэс суурь болдог. Ахмад настай үйлчлүүлэгчийн амьдрал аж байдалд нөлөөлж байгаа ямар зүйлүүд байгааг ойлгосноор үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх нөхцөл бүрдэнэ. Энэ нь нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгчийн тухай, түүний өнгөрсөн амьдрал, өнөөгийн нөхцөл байдлыг олж мэднэ гэсэн үг бөгөөд энэ үйл явц нь ямар ч үйлчлүүлэгчтэй ажиллахад ижил төстэй. Харин ахмад настны хувьд нийгэм сэтгэл зүйн нөхцөл байдлаас гадна тэдний орчин, эрүүл мэндийн байдал чухал мэдээлэл болно. Өөр нэгэн ялгаатай тал нь ахмадуудын мэдээлэл баялаг олон зүйлийг агуулсан байдаг. Иймд асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай холбогдох мэдээллийг цуглуулах чадвар ахмадуудтай ажиллаж буй нийгмийн ажилтнуудад чухал юм.

Нийгмийн ажилтнууд үйлчлүүлэгчийн нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ системт болон давуу талд тулгуурлах хандлагаар хандаж хувь хүнийг орчинтой нь авч үзэх хэрэгтэй болно. Үйлчлүүлэгч бие физиологи болон сэтгэл санааны хувьд ямар байна, эрүүл мэндийн ямар асуудал тулгараад байна, тэдний нойр, хооллолт ямар байна, нийгмийн үүргийн хувьд ямар өөрчлөлт орсон байна, найз

нөхөд, гэр бүл зэрэг бусад хүмүүстэй харьцах харилцаа нь ямар байна, эм тариа хэтрүүлэн хэрэглэх эсвэл бусдын хүчирхийлэл дарамтад байгаа эсэх, ахуйн болон бусад төрлийн ямар эрсдэл байна, өөрийн эрүүл ахуйг сахих болон бие даан амьдрах чадвар нь ямар байна, тэдний асрамж халамж, нийгмийн дэмжлэг ямар байна гэдгийг нөхцөл байдлын үнэлгээгээр илрүүлж тодорхойлно.

Нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ хүнийг орчинд нь системтэйгээр авч үзэх арга зүйгээр нийгмийн ажилтнуудын ашиглах аргачлал буюу үйлчлүүлэгчээс тодруулах асуултуудын жагсаалтыг Померой, Холлеран нар 2003 онд боловсруулсан байна (Тайлбар 1).

Тайлбар.1. Померой, Холлеран нарын боловсруулсан нийгмийн ажилтан үйлчлүүлэгчээс асууж тодруулах асуултуудын жагсаалт

- Үйлчлүүлэгчийн гадаад төрх байдлын талаар мэдээлэл (хэр зэрэг хувцасласан, цэвэр цэмцгэр хувцасласан эсэх, туранхай, тарган байдал, бие махбодын шинж тэмдэг, хувийн ариун цэвэр хэр хангасан байдал г.м);

- Эрүүл мэнд, биологи, организмын талаар мэдээлэл (үйлчлүүлэгчийн өвчний түүх, гэр бүлийн өвчний түүх, бие физиологийн гэмтэл согог байгаа эсэх, сэтгэц танин мэдэхүйн үйл ажиллагааны эмгэг согог байгаа эсэх, ямар эм тариа хэрэглэж байгаа, хооллолтын дуршил дэглэм ямар болох, унтаж амардаг хэмнэл, өөрийнхөө эрүүл мэндийн байдлыг юу гэж тодорхойлж байгаа, тулгамдсан ямар асуудал байна, гэр бүл, бусад хүмүүст үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал, түүнд тулгамдсан асуудал ямар нөлөөтэй байгаа г.м)

- Хувь хүний хөгжил болон аливаа шилжилт өөрчлөлтийн талаар мэдээлэл (хувь хүн эсвэл гэр бүлийн хөгжлийн явцад гардаг хүүхэд төрсөн, гэр бүлийн гишүүн тусгаарласан, нас барсан, тэтгэвэрт гарсан гэх мэт шилжилтийн үйл явц үйлчлүүлэгчид тохиолдсон эсэх, тухайн үеийн амьдралын хэрэгцээ түүнд хэрхэн нөлөөлж байгаа, үйлчлүүлэгчид туслах нийгмийн дэмжлэгийн систем ямар болох, тулгарч байгаа ямар асуудал байна, эдгээр асуудал нь гэр бүл, бусад хүмүүст хэрхэн нөлөөтэй байна г.м),

- Асуудлыг шийдвэрлэх, бэрхшээлийг даван туулах чадварын талаар мэдээлэл (үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэх, бэрхшээлийг давах, өөрийгөө хамгаалах арга механизм ямар болох, бэрхшээлийг давах ямар чадвартай байна, асуудлыг шийдвэрлэхэд өөрийн арга барил нь болж байгаа эсэхийг үйлчлүүлэгч юу гэж үзэж байгаа, ямар тулгамдсан асуудал байна, эдгээр нь гэр бүл, бусад хүмүүст хэрхэн нөлөөлж байгаа, үйлчлүүлэгч ямар арга хэмжээ авч байгаа, г.м),

- Хямрал үүсгэх хүчин зүйлийн мэдээлэл (үйлчлүүлэгчийн амьдралд ямар хямралт хүчин зүйл голлож байна, эдгээр нь хэр удаан хугацаанд үйлчлүүлэгчид нөлөөлж байгаа, дотоод эсвэл гадаад нөхцөл байдлаас хамаарсан хямралын хүчин зүйл болох, орчны эсвэл соёлын ямар хүчин зүйл хямрал үүсэхэд нөлөөлж байна, харилцааны асуудлаас, ажлаас болсон, эсвэл архаг шинж чанартай гэх мэтээр үйлчлүүлэгчийн амьдралд тохиолдож буй стресст ямар шинж тэмдгүүд байна, хямрал стрессийг шийдвэрлэх талаар үйлчлүүлэгч ямар оролдлого хийсэн, тулгамдсан асуудал, стресс нь хүмүүс, гэр бүлд хэрхэн нөлөөтэй байгаа, г.м)

- Хүмүүстэй харилцах харилцаа ба нийгмийн чадвар (үйлчлүүлэгч хэнтэй амьдардаг, дотны хүн хэн болох, үйлчлүүлэгчийн харилцааны чадвар ямар болох, тэр нийгмийн ямар ямар үйл ажиллагаанд оролцдог, тэрээр өөрт туслах дэмжлэгийн хүрээг юу гэж үздэг, хүмүүстэй харилцах харилцааны онцлог төрх шинж байгаа эсэх, хүмүүстэй хэр удаан харилцаатай байдаг, бусад хүмүүсийг ойлгож харьцах чадвартай эсэх, хүмүүстэй харилцахдаа түгших, айх зэргээр стресс бухимдалд ордог эсэх, тухайн цаг үед харилцааны ямар нэг асуудалтай эсэх, үйлчлүүлэгч ямар нэг арга хэмжээ авсан эсэх, үйлчлүүлэгчийн асуудлууд гэр бүл, болон бусад хүмүүст ямар нөлөөтэй байгаа, г.м),

- Үйлчлүүлэгчийн зан байдлын талаар мэдээлэл (чичрэх, балмад загнах, хэт хөдөлгөөнтэй байх гэх мэт сонин хачин зан үйл гаргаж байгаа эсэх, нийгмийн ажилтантай уулзах үедээ биеэ зөв авч явж байгаа эсэх, ажилтны зүгээс үйлчлүүлэгчтэй харьцахдаа хэр тухтай сэтгэгдэлтэй байгаа, зан байдлын тулгамдсан асуудалтай эсэх, ямар арга хэмжээ авч байгаа, үйлчлүүлэгчийн асуудал нь гэр бүл бусад хүмүүст ямар нөлөөтэй байгаа г.м)

- Бэлгийн зан үйлийн талаар мэдээлэл (үйлчлүүлэгчид бэлгийн харилцааны ямар нэг хүндрэл тулгарсан эсэх, энэ нь сэтгэл санааны, бие махбодын, уламжлал соёлын аль талаас шалтгаалсан асуудал болох, асуудал нь хэр хугацаанд үргэлжилсэн, тухайн асуудлаас шалтгаалаад үйлчлүүлэгчийн бусад үйл ажиллагаа, нөхцөл байдалд нөлөөлөх зүйл гарсан эсэх, тэрээр яаж шийдвэрлэх оролдлого хийсэн, тулгарсан асуудал нь гэр бүл бусад хүмүүст ямар байдлаар нөлөөлсөн, г.м)

- Оюун ухаан, сэтгэцийн талаар мэдээлэл (үйлчлүүлэгчийн боловсролын түвшин, оюун ухаан, сэтгэн бодох чадвар ямар болох, сэтгэц мэдрэлийн ямар нэг асуудал гарч байсан эсэх, хий хоосон зүйл, сонин хачин юм ярьж өвөрмөц үг хэллэг хэрэглэж байгаа эсэх, өөрийгөө илэрхийлэх чадвар хэр байгаа, бодитойгоор бодож төлөвлөх, эрсдэл үр дагаврыг тооцох гэх мэтээр аливааг дүгнэж эргэцүүлэх чадвар нь ямар байгаа, шийдвэр гаргах чадварын түвшин, энэ хүрээнд тулгамдсан ямар асуудал байна, эдгээрийг хэрхэн шийдвэрлэх алхам хийсэн, үйлчлүүлэгчийн асуудал нь гэр бүл бусад хүмүүст хэрхэн нөлөөлж байгаа, г.м),

- Сэтгэл санааны байдлын мэдээлэл (үйлчлүүлэгчийн сэтгэл санааны байдлын ерөнхий илэрхийлэл ямар байгаа, сэтгэл санаа нь тогтвортой, эсвэл өөрчлөлттэй эсэх, өөрчлөлт нь орчин нөхцөл байдлаас хамаарч байгаа эсэх, үйлчлүүлэгчийн илэрхийлж байгаа сэтгэл санааны байдал нь нөхцөл байдалтайгаа нийцэж байгаа эсэх, сэтгэл санааны байдал нь үйлчлүүлэгчийн нийгэм сэтгэл зүйн үйл явцад нөлөөлж байгаа эсэх, хэрэв тийм бол хэр удаан хугацаанд нөлөөтэй, үйлчлүүлэгч асуудлаа шийдэх ямар алхам хийсэн, үйлчлүүлэгчийн асуудал гэр бүл, бусад хүмүүст хэрхэн нөлөөлж байгаа, г.м)

- Өөрийгөө үзэх үзлийн талаар мэдээлэл (үйлчлүүлэгч өөрийгөө хүндэтгэж авч үздэг үү, өөрийгөө чадвартай гэж үнэлдэг үү, өөрийнхөө талаар бодитой үнэлж байгаа эсэх, өөрийн үнэлэмж, өөрийгөө үзэх үзлийн хувьд үйлчлүүлэгчид асуудал байна уу, тулгарсан асуудлаа шийдвэрлэх ямар алхам хийсэн бэ, гэр бүл, бусад хүмүүст тулгарсан асуудал нь ямар нөлөөтэй байна, г.м)

- Сэдэл сонирхлын талаар мэдээлэл (үйлчлүүлэгч өөрчлөлт хийхийг хүсэж байгаа эсэх, хэр зэрэг сэдэл тэмүүлэлтэй байна, гадаад болон дотоод сэдэл өдөөгч хүчин зүйлс нь юу вэ, үйлчлүүлэгч ямар нэг зорилготой байна уу, өөрийнхөө нөхцөл байдлыг сайжруулах, өөрчлөх талаар үйлчлүүлэгч төсөөлж арга зам хайж байна уу, дээрх асуудал нь гэр бүл, бусад хүмүүст ямар байдлаар нөлөөлж байна, г.м)

- Гарал үүсэл, соёлын талаар мэдээлэл (үйлчлүүлэгч өөрийгөө гарал үүсэл, соёл уламжлалын хувьд ямар бүлэгт харьяалуулж тодорхойлж байна, үүндээ хэр сэтгэл хангалуун байна, үйлчлүүлэгчид өөрийгөө тодорхойлох үүднээс ямар нэг зөрчил байна уу, үйлчлүүлэгч харьяалагдаж буй бүлгийн гишүүдийн зүгээс болон бусдын зүгээс ямар нэг дарамт шахалт мэдэрч байна уу, соёлын ямар ялгаа үйлчлүүлэгчид тулгарч байна, тулгамдаж буй ямар асуудал байна, энэ нь гэр бүл бусад хүмүүст хэрхэн нөлөөлж байна, г.м)

- Нийгмийн үүргийн талаар мэдээлэл (үйлчлүүлэгч өнөөгийн байдлаар ямар үүргүүдийг гүйцэтгэж байна, сайн дураар уу эсвэл албаар нийгмийн өөрт оногдсон үүргүүдийг гүйцэтгэж байна уу, үүргээ гүйцэтгэх, хэд хэдэн үүргийг хослуулахад хүндрэл гарч байгаа эсэх, тулгарсан ямар асуудал байна, эдгээр нь гэр бүл, бусад хүмүүст ямар байдлаар нөлөөтэй байна, г.м)

- Шашин шүтлэг, оюун санааны байдал, итгэл үнэмшлийн талаар мэдээлэл (үйлчлүүлэгч тодорхой шашин шүтдэг эсэх, оюун санааны хувьд юуг биширч дагаж баримталдаг, итгэл үнэмшил нь үйлчлүүлэгчийн давуу тал болох эсэх, үйлчлүүлэгч өөрийн итгэл үнэмшлээс нь хамаарсан асуудал гардаг гэж үздэг эсэх, ямар тулгамдсан асуудал байна, ямар арга хэмжээ шийдвэрлэхээр оролдсон, үйлчлүүлэгчийн амьдралын зорилгын талаарх үзэл, түүний итгэл үнэмшил нийгэм сэтгэл зүйн байдалд нь сөргөөр нөлөөлдөг эсэх, шашин шүтлэг, оюун санааны байдалтай холбоотой үйлчлүүлэгчийн асуудал нь гэр бүл бусад хүмүүст ямар нөлөөтэй байгаа, г.м)

- Үйлчлүүлэгчийн бусад давуу чанар (үйлчлүүлэгч нэмж ямар авъяас, давуу чанарыг дурдсан болох).

Монголд өнөөгийн байдлаар хүн амд, үүн дотроос ахмад настнуудад нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, мэргэжилтнүүд үйлчлүүлэгчийн нөхцөл байдлын үнэлгээ

хийхдээ болон үйлчилгээг хэрэгжүүлэхдээ мөрддөг тусгай батлагдсан аргачлал, арга зүй байхгүй байгаа бөгөөд нийгмийн хамгааллын болон нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний стандарт хэм хэмжээг боловсруулан мөрдөх асуудал яригдаж байгаа билээ. Тэгвэл нийгмийн ажлын үйлчилгээний стандарт арга зүйг тогтоохдоо дээрх судлаач эрдэмтдийн боловсруулсан аргачлалаас санаа авч өөрийн орны ахмад настнуудын бие физиологи, амьдралын чанар, хэв маягт тохирсон нөхцөл байдлын үнэлгээ хийх аргачлалыг боловсруулан ашиглах хэрэгцээ тулгарч байна.

Ахмад настнуудтай ажилладаг мэргэжилтнүүд эрүүл мэндийн асуудлаар гүнзгий ойлголт мэдлэгтэй байх шаардлагатай байдаг. Хэдийгээр тухайн ахмад настан эрүүл мэндийн хувьд илэрхий эмгэггүй ч гэсэн тэдэнтэй ажиллах явцад эрүүл мэндийн талаар нь асууж үнэлгээ хийх хэрэгтэй юм. Иймд архаг өвчин хууч, өвчний хурцдал, ямар эмчилгээ түгээмэл хэрэглэгддэг, ямар осол гэмтэл хэрхэн нөлөөлж болох зэрэг асуудлаар мэдлэгтэй байвал зохино. Түүнчлэн өрхийн эмч болон тухайн настны үйлчлүүлдэг эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэнтэй холбоо тогтоож холбогдох мэдээллийг авч болно. Нөхцөл байдлын үнэлгээ хийхэд настай хүмүүсийн хувьд бие махбодын болон эрүүл мэндийн байдал нь сэтгэл санааны хямралт байдлыг нь халхалдаг болохыг анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл сэтгэл санааны хувьд хямарснаас бие махбодын шинж тэмдэг илүүтэй илэрч толгой өвдөх, бие нь муудах, ядрах байдал гарч байж болно. 55-80 насны 900 өндөр настнуудын дунд явуулсан судалгаагаар цусны даралт ихсэх (26,5%), зүрх судасны өвчин (14,2%), хоол боловсруулах эрхтний (13,6%), бөөрний (10,1%), мэдрэлийн (4,2%), уушигны (2,6%) архаг хууч өвчин элбэг гарчээ. Ахмад настнуудын дунд хоол идэх дуршил сонирхол нь хааяа буюу заримдаа буурдаг гэж 61,7%, нойр муудах явдал заримдаа гардаг гэж 60,6% нь илэрхийлсэн байна.

Өндөр настнуудын дунд түгээмэл гардаг эрүүл мэндийн асуудал бол депресс буюу сэтгэл гутрал, деменция буюу зөнөглөх өвчин байдаг байна. Сэтгэл гутралд орсноос гуниглах, итгэл найдваргүй болох, бие нь туйлдаж ядрах, хоолонд дургүй болох, эсвэл хэт их идэх, нойронд муудах гэх мэт шинж тэмдгүүд илэрнэ. Түүнчлэн сэтгэл гутралтай үедээ настай хүмүүс юм санах нь муу байх, аливааг ойлгож хүлээж авах оюуны чадвар нь доройтох байдал илэрч болно. Гэтэл дээрх шинж тэмдгийг деменция буюу зөнөгрөх өвчний шинж гэж андуурч хэт оношлогоо хийх тохиолдол мэргэжилтнүүдэд тохиолддог байна. Нөгөөтэйгүүр, хүн өндөр наслахад насжилтын үйл явцын улмаас гардаг өөрчлөлтүүдийг өвчинтэй холбож үзэхээс болгоомжлох хэрэгтэй. Бэлгийн харилцааны сонирхол буурах, физиологийн хувьд бие эрхтэний зарим үйл ажиллагаа алдагдах нь насжилтын жирийн үйл явц болохыг мэргэжилтнүүд мэдэж байх хэрэгтэй байна.

Ахмад настантай ажиллахад тэдэнд хэн ямар халамж анхаарал тавьдаг болохыг судлах хэрэгтэй ажээ. Олон нийтэд тулгуурласан нийгмийн үйлчилгээний байгууллага, эсвэл гэр бүл, эсвэл асрамжийн газар гэх мэт хаана тухайн үйлчлүүлэгч амьдарч харьяалагддагаас үл хамааран албан болон албан бус нийгмийн дэмжлэгийн системийг тодорхойлж үнэлгээ өгөх шаардлагатай. Тэдэнд дэмжлэг үзүүлж анхаарч халамжлах нөхцөл байдал ямар байна, ямар боломж байна гэдгийг гэр бүл, хөршүүд, садан төрөл, найз нөхөд, харьяалагддаг болон үйл ажиллагаанд нь хамрагддаг байгууллага, хороо хэсэг зэргийг тодруулах замаар олж мэдэх бололцоотой. Гэр бүлийн мэдээлэл нь үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж ямар байна, өөрийнхөө амьдралыг юу гэж үзэж байна гэдгийг тодорхойлох гол мэдээллийг өгдөг. 1998-1999 онд хийгдсэн “Өндөр настны ахуй нөхцөлийн түүвэр судалгаа” –гаар өндөр настантай өрхийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсан байна. Өндөр настантай өрхийн хэлбэрээр авч үзвэл ганц бие өрх 11,6%, ам бүлээрээ байгаа өрх 38%, нийлмэл ам бүлтэй өрх 49,2%, холимог ам бүлтэй өрх 1,2% байна. Ихэнх ахмад настнууд гэр бүл, хамаатан садны хүмүүстэй амьдарч байгаа энэ нөхцөлд өндөр настанд үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээг төрөөс үзүүлэхдээ гэр бүлд тулгуурласан хэлбэрээр үзүүлэх нь оновчтой бодлого үйл ажиллагаа болж байна.

Ахмад настнуудын хувийн асаргаа буюу өөрийгөө авч явах байдал, өдөр тутмын аж төрлийн ба ойр зуурын ажил үйл гүйцэтгэх чадварыг нөхцөл байдлын үнэлгээгээр тодорхойлно. Өндөр настнуудын өөрсдөө хөдөлж гүйцэтгэх үйл хөдлөл, өдөр тутмын үйл ажлыг зохицуулах чадварыг тодорхойлох оношлогооны

стандарт хэмжүүрийг эрдэмтэд судалж тодорхойлсныг практикт, ялангуяа барууны орнуудад нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд ашиглаж байна. Эдгээрийг настай хүмүүсийн функциональ чадварын үнэлгээ гэх бөгөөд үүнийг ашиглан настай үйлчлүүлэгчийн өөрсдөө хөдөлж ойр зуурын өдөр тутмын амьдралын ажил үйл гүйцэтгэх чадварын түвшинг (instrumental activities of daily living) үнэлнэ гэсэн үг. Барууны орнуудын нийгмийн ажилтнуудын ахмад настантай ажиллахдаа нөхцөл байдлын үнэлгээ хийхэд ашигладаг настай хүний өдөр тутмын амьдралын ажил үйл гүйцэтгэх чадварын түвшинг тодорхойлох үнэлгээний аргыг та бүхэнд толилуулья (Хүснэгт 1). Гэхдээ энэхүү үнэлгээний арга нь барууны улс орны хөгжлийн түвшин, хүмүүсийн аж амьдралын хэв маяг зэрэгт үндэслэгдэн боловсруулагдсан учраас манай орны нөхцөл, аж төрөх хэв маяг, хүмүүсийн бие даах чадварыг тодорхойлох нөхцөл байдлаас ялгаатай болох нь илэрхий. Тухайлбал хүмүүсийн өдөр тутмын ажил үйл гүйцэтгэх чадварыг үнэлэхдээ утсаар ярих чадварыг хамруулсан байна. Гэтэл энэ нь манай орныхоос ихээхэн ялгаатай бөгөөд энэ чадварыг настай хүмүүсийн бие даах чадварыг тодорхойлох үнэлгээний үзүүлэлт болгож оруулах үндэслэл манайд бага тэр ч байтугай үүнийг оруулах боломжгүй юм. Түүнчлэн үйлчлүүлэгчийн хувцсаа угаах чадварыг авч үзэхдээ барууны орны ойлголтоор угаалгын машиныг ашиглан хувцас хунараа угаах талаар асууж байгаа гэдгийг тэмдэглэх хэрэгтэй байх. Гэтэл манай орны нөхцөлд энэ ойлголтоор хувцсаа угаах чадварыг авч үзэхгүй нь тодорхой. Нэмж нэг зүйлийг тэмдэглэж хэлэхэд барууны орны нийтийн тээврийн унаа нь тэргэнцэртэй, таягтай, дугуйтай түрдэг хэрэгсэлтэй хүмүүст зориулсан тусгай өргөх тоноглолтой байдаг учраас тэд автобус унаагаар бусдын туслалцаатай, эсвэл ганцаараа явах бололцоотой байдаг. Энэ утгаар нь гадуур зорчих чадварыг үнэлж байгаа гэдгийг ойлгох нь зүйтэй юм. Гэхдээ бусад орны нийгмийн ажилтны ашигладаг үйлчлүүлэгчийн нөхцөл байдлын үнэлгээ хийдэг нэг аргыг танилцуулснаар манай улсын нийгмийн ажил, нийгмийн хамгааллын мэргэжилтнүүд, судлаач, эрдэмтдэд өөрийн орны нөхцөл байдал, хүмүүсийн аж төрөх хэв маяг, хувь хүний бие даах чадварын түвшин зэргийг судлан нийгмийн ажилтнууд үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхдээ үндэслэх онцлог арга зүй шалгууруудыг тодорхойлох хэрэгцээ байна гэдгийг гаргаж тавихыг зорьсон билээ.

Хүснэгт 1. Өндөр настнуудын өдөр тутмын амьдралын ажил үйл гүйцэтгэх чадварын түвшинг тодорхойлох үнэлгээний асуултууд

	Чадварын түвшинг тодорхойлох чиглэлүүд	Оноо
1	Утас ашиглах чадвар	
	1. Өөрөө дугаараа залгаад утасдаж чадна.	1
	2. Мэддэг дугааруудаа залгаж чадна	1
	3. Утсаар хариу өгөх боловч өөрөө залгаж ярьдаггүй.	1
	4. Утас ашигладаггүй.	0
2	Ойр зуурын худалдаа хийх чадвар	
	1. Өөрөө дэлгүүр явж хэрэгтэй зүйлсээ авдаг	1
	2. Бага зэргийн худалдааг хийж чадна.	0
	3. Дэлгүүрээс юм авахдаа хүнтэй явах хэрэгтэй байдаг.	0
	4. Өөрөө бие дааж дэлгүүрт худалдаа хийж чадахгүй.	0
3	Хоол хүнсээ бэлдэх чадвар	
	1. Тохирсон хоол хүнсийг өөрөө зохицуулж бэлтгэж чадна.	1
	2. Хэрэв материал нь байвал тохирсон хоол хүнсээ өөрөө бэлтгэж идэж чадна.	0
	3. Хоол хүнсээ бэлтгэж, халааж идэж чадах боловч шаардлага хангахуйц хоол хүнс хэрэглэхгүй байх.	0
	4. Хоол хүнсийг нь бэлтгэж өгөх шаардлагатай.	0
4	Гэр орны ажил хийх чадвар	

	1. Гэр орны ажлаа өөрөө хийдэг, заримдаа туслалцаа авдаг.	1
	2. Ороо засах, аяга тавгаа угааж ширээгээ цэвэрлэх гэх мэтээр өдөр тутмын хөнгөн ажлуудыг хийдэг.	1
	3. Гэр орноо цэвэрлэх өдөр тутмын хөнгөн ажлуудыг хийж чадах боловч цэвэр байдлыг хангалттай бий болгож чадахгүй байх	1
	4. Гэр орны ажлыг хийхэд туслалцаа хэрэгтэй	1
	5. Гэр орны ажил хийхэд ер оролцдоггүй.	0
5	Хувцсаа угаах чадвар	
	1. Өөрийн хувцас хунараа угааж цэвэрхэн явж чадна.	1
	2. Бага хэмжээний угаалгыг өөрөө хийдэг.	1
	3. Хүнээр угаалгаа хийлгэх хэрэгтэй.	0
6	Тээврийн хэрэгсэл ашиглах чадвар	
	1. Ийш тийшээ бие даагаад зорчиж чадна.	1
	2. Зөвхөн таксигаар явах хэргээ бүтээдэг, өөр төрлийн унаа ашигладаггүй.	1
	3. Хүнтэй цуг нийтийн тээврийн хэрэгслээр явдаг.	1
	4. Бусдын туслалцаагүйгээр гадагшаа явж чадахгүй.	1
	5. Хаашаа ч явдаггүй.	0
7	Эм тариа хэрэглэх байдал	
	1. Заасан цаг хугацаанд шаардлагатай хэмжээний эмийг өөрөө зохицуулаад ууж хэрэглэж чадна.	1
	2. Урьдчилан бэлтгэж өгсөн эм тариаг зааврын дагуу хэрэглэдэг.	0
	3. Өөрөө бие даагаад эм тариагаа тохируулж хэрэглэж чадахгүй.	0
8	Мөнгө санхүү зохицуулах чадвар	
	1. Санхүү мөнгөө өөрөө зохицуулж чадна.	1
	2. Өдөр тутмын худалдааг тооцоолж хийж чадах боловч том зүйл худалдаж авах, банканд гүйлгээ хийхэд туслалцаа авах шаардлагатай.	1
	3. Мөнгө зарцуулж зохицуулж чадахгүй.	0
	НИЙТ ОНОО	

*Эх сурвалж: Cathleen Jordon, Cynthia Franklin. Clinical Assessment for Social Workers: Quantative and Qualitative Methods. 2003 . 2<sup>nd</sup> Ed. Хуудас 242-м уу татсан: M.P. Lawton and E.M. Brody. (1969). Assessment of older people: Self-maintaining and instrumental activities of daily living. Gerontologist, 9, 179-186.*

Дээрх үнэлгээг бөглөсний дараа нийгмийн ажилтан гарын үсгээ зурдаг байна. Үнэлгээний үр дүнд өндөр настай үйлчлүүлэгч нь бие даах чадвараа хэр алдсан, өдөр тутмын ажил үйл гүйцэтгэх чадвар ямар түвшинд байгааг хөнгөн, дунд зэрэг, их гэсэн түвшингээр тодорхойлж холбогдох үйлчилгээ, арга хэмжээг төлөвлөнө.

**Монгол улсад өнөөр настнуудын өдөр тутмын үйл хөдлөлийн талаар анх удаа 1999 онд хийгдсэн “өндөр настны ахуй нөхцөлийн түүвэр судалгаа” –гаар судалсан байна. Үүнд:**

- Бөхийх болон явган суухад бэрхшээлтэй,
- 5кг-аас илүү ачаа өргөх буюу авч явахад бэрхшээл гардаг,
- 500 метр орчим алхахад бэрхшээлтэй,
- 3-5 шат буюу өндөрлөг газар өгсөх буюу уруудахад бэрхшээл,
- Гараараа юм барих, атгахад бэрхшээл,
- Гэр дотроо явахад бэрхшээл,
- Хувцсаа өмсөхөд бэрхшээл,
- Хоол хүнсээ идэж уухад бэрхшээл,
- Эм тариа бэлдэхэд бэрхшээл,
- Тээврийн хэрэгслээр явахад гарах бэрхшээл гэсэн үзүүлэлтүүдээр судалгаа хийгджээ.

Ахмад настнуудаас дээрх үзүүлэлтүүдээр судалгаа авахдаа огт бэрхшээлгүй, бага зэрэг бэрхшээлтэй, хааяа бэрхшээл гардаг, ихэвчлэн бэрхшээл гардаг гэсэн 4 янзаар хариулт авчээ. Хүснэгт 2-оос Монголын ахмад настнуудын өдөр тутмын үйл хөдлөл, тэдэнд ахуйн хүрээнд болон бусад үед тулгардаг бэрхшээлийн талаар ерөнхий дүр зургийг харж болно.

Хүснэгт 2.

Өдөр тутмын үйл хөдлөл	Огт бэрхшээлгүй	Бага зэрэг/ Хааяа	Ихэвчлэн
Бөхийх болон явган суухад бэрхшээлтэй	32,7%	26,9%	40,5%
5кг-аас илүү ачаа өргөх буюу авч явахад	28%	22,1%	49,8%
500 метр орчим алхахад бэрхшээлтэй	36,3%	19,6%	39,1%
3-5 шат (өндөрлөг газар) өгсөх/уруудахад Бэрхшээл	29,3%	30,7%	40%
Гараараа юм барих, атгахад бэрхшээл	43,3%	30,5%	26,3%
Гэр дотроо явахад	83,6%	16,4%	
Хувцсаа өмсөхөд	90,1%	9,9%	
Хоол хүнсээ идэж уухад	91,2%	8,8%	
Эм тариа бэлдэхэд	83,6%	16,4%	
Тээврийн хэрэгслээр явахад	71,3%	28,7%	

Өндөр настнуудын өдөр тутмын аж төрөл, үйл хөдлөлд тулгарч байгаа бэрхшээл нь архаг хууч өвчтэй хүмүүсийн хувьд, төрөлхийн болон олдмол согогтой хүмүүсийн хувьд, нас нэмэгдэхийн хэрээр ялгаатай болохыг тухайн судалгааны тайлангаас дэлгэрэнгүй үзэх боломжтой.

Нөхцөл байдлын үнэлгээ хийсний үндсэн дээр нийгмийн ажилтан үзүүлэх үйлчилгээнийхээ зорилгыг тодорхойлно. Зорилго нь аль болох хэмжигдэхүйц, тодорхой, хэрэгжих боломжтой, тодорхой хугацаатай байх нь зүйтэй ажээ. Жишээ нь үйлчлүүлэгч 2 сарын дараа эмчилгээ эхлүүлэх талаар шийдвэр гаргасан байна, үйлчлүүлэгч 1 сарын дараа гэрийн үйлчилгээнд хамрагдсан байна гэх мэт. Зорилгыг тодорхойлохдоо үйлчлүүлэгчтэй зөвшилцөж төлөвлөнө. Ингэснээр үйлчлүүлэгчийн өөрийгөө тодорхойлох, өөрийн асуудлын талаар бие дааж шийдвэр гаргах хэрэгцээ хангагдана. Нөгөө талаар ажилтны хийх ажлыг чиглүүлж хариуцлагыг өндөржүүлэх бөгөөд ажлын үр дүнг хянаж тооцоход ач холбогдолтой.

Нийгмийн ажилтан нийгмийн ажлын үйлчилгээний төлөвлөгөө гаргахдаа дараах асуудлуудыг анхаарч харгалзах шаардлагатай байдаг. Үүнд:

- Бусад мэргэжлийн хүмүүсийн туслалцаа авах асуудал байгаа эсэхийг тодорхойлох. Тухайлбал нийгмийн ажилтан нь эмч, сэтгэл зүйч, сэтгэцийн эмч зэрэг мэргэжилтнүүдтэй холбоотой ажиллах шаардлага гарна.
- Үйлчлүүлэгчид одоо байгаа болон боломжтой байгаа нөөцийг тодорхойлох. Өөрөөр хэлбэл үйлчлүүлэгчид нийгмийн дэмжлэгийн ямар систем байна, түүний орон байр, унаа, мөнгө гэх мэт нөөцийн боломжийг тодруулна.
- Үйлчлүүлэгчийн хэрэгцээ, тулгамдсан асуудлыг яаралтай шинж чанар, ач холбогдлын хувьд эрэмбэлэн эхлээд ямар асуудлыг шийдвэрлэх, дараа нь ямар арга хэмжээ авах зэргээр дараалал тогтооно.
- Үйлчлүүлэгчтэй хамтарч нийгмийн ажлын үйлчилгээний зорилгыг хэрхэн тодорхойлох, ямар гэрээ хэлэлцээр хийх асуудлыг тодруулна.
- Нийгмийн ажлын үйлчилгээний үр дүнг тодорхойлох мониторинг ба үнэлгээний үзүүлэлтийг тогтоох гэсэн эдгээр асуудлыг анхаарч хэрэгжүүлнэ.

### *Нийгмийн ажлын үйлчилгээ интервенц үзүүлэх нь*

Нийгмийн ажлын үйлчилгээг ахмад настай хүмүүст үзүүлэх явцад тэдэнтэй ажиллаж буй мэргэжилтнүүдэд сэтгэлийн тэнхээ хат, тэвчээр чухал байдаг ажээ. Үйлчлүүлэгчид бие тэнхээ доройтох, өвчилж бие нь муудах, хэн нэг нь нас барснаас болж санаа сэтгэлээр унах, амархан гомдох зэрэг явдлууд тохиолдож болно. Тэдэнтэй ажиллаж байхад ярьж хэлэлцэж буй сэдвээсээ хазайх, яриагаа зогсоохгүй байх, уулзалт дууслаа ч явахгүй, эсвэл ажилтныг явуулах дургүй байх гэх мэт асуудлууд тулгарч болно. Иймд нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй уулзах уулзалтыг бүтэц, зохион байгуулалтын зүгээс зөв зүйтэй зохицуулах, тэднийг уурлуулж бухимдуулахгүй, гомдоохгүйгээр харилцаагаа авч явах хэрэгтэй болдог. Хэрэв ингэж чадахгүй бол үйлчлүүлэгч сэтгэлээ хуваалцахгүй байх, үйлчилгээнээс татгалзах нөхцөл байдал үүсч болно. Ахмад настнуудад үйлчилгээ үзүүлэхдээ тэдэнд шууд нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөхөөс гадна мэдээллээр хангах, хэрэгцээт үйлчилгээнд тодорхойлж холбож зуучлах хэрэгтэй байдаг. Иймд ахмадад үйлчилгээ үзүүлдэг хамтрагч байгууллагуудын жагсаалтыг судалж гаргах нь тустай.

Ахмад настнуудын хувийн асаргаа буюу өөрийгөө авч явах байдал, өдөр тутмын аж төрлийн ба ойр зуурын ажил үйл гүйцэтгэх чадварыг нөхцөл байдлын үнэлгээгээр тодорхойлсны үндсэн дээр нийгмийн ажилтан нь тухайн үйлчлүүлэгчид гэрийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, оршин сууж буй орон нутаг дахь үйлчилгээнд холбох, тодруулбал гэр цэвэрлэх, угаалга хийх, халуун хоолоор үйлчлэх, асрагч сувилагч гэрээр үйлчлэх, бусад туслалцааг зохицуулж үйлчилгээгээр хангах арга хэмжээг авна.

Ахмад настнуудад үйлчилгээ үзүүлэхэд гэр бүлийн гишүүдийг татан оролцуулж тэдэнтэй хамтран ажиллахыг анхаарах нь зүйтэй. Манайд хийгдсэн өндөр настнуудын дундах судалгаагаар настай хүмүүст үзүүлдэг үйлчилгээ тусламжийн 80 хувийг гэр бүлийн гишүүд, хамаатан садангаас үзүүлдэг болохыг тэмдэглэсэн байна. Нөгөөтэйгүүр ахмад настнуудын дунд хүчирхийлэл дарамт нэлээдгүй байгааг судалгаагаар илрүүлсэн байдаг. Иймд настангуудад үзүүлэх гэр бүлийн гишүүд, хөрш, найз нөхдийн дэмжлэг туслалцааг нэмэгдүүлэх, тэдний анхаарал халамжийг сайжруулах асуудлыг нийгмийн ажилтан үйлчилгээндээ анхаарч хэрэгжүүлэх нь зүйтэй. Манай улсын нийгмийн хамгааллын үйлчилгээний түгээмэл хэлбэр бол албан байгууллага, оршин суугаа газрын захиргаа харьяаллын ахмад настнуудын бүртгэл судалгааг гаргаж, тэдний нийгмийн амьдралд оролцох оролцоог хангах, хөгжүүлэх, эрхийг хамгаалахад чиглэсэн шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэхээс гадна соёл олон түмний арга хэмжээнд хамруулах, гавьяаг мөнхжүүлэх, тэдний туршлагаас суралцах үйл ажиллагааг зохион байгуулдаг билээ. Эдгээр ажил үйлчилгээг зохион байгуулахад хорооны нийгмийн ажилтнууд гол үүрэгтэй байдаг. Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх төдийгүй ахмад настнуудыг тэтгэвэрт гарахад бэлтгэх, тэтгэвэрт гарсан настангуудад, эрх нь зөрчигдсөн хүмүүст шаардлагатай үйлчилгээг тэдний ажиллаж байсан байгууллага, харьяа орон нутагтай хамтарч хүргэхэд ахмад настантай ажилладаг нийгмийн ажилтнууд анхаарч ажиллавал зохино.

Үйлчилгээг төгсгөх нь

Үйлчлүүлэгчийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж тэдний хэрэгцээг төлөвлөсний дагуу тодорхой хэмжээгээр хангасан үйлчилгээ үзүүлсний эцэст нийгмийн ажилтны үйлчилгээний төгсгөл шат ирнэ. Олон шалтгаанаар үйлчлүүлэгч болон нийгмийн ажилтны харилцаа дуусгавар болж болно. Нийгмийн ажилтан ажлаасаа шилжих, өөр асуудлаар ажиллахаар өөрчлөгдөх, үйлчлүүлэгч асуудлаа шийдсэн тул, эсвэл нүүж шилжих болсон, мөн түүнчлэн үйлчлүүлэгчийн хүсэлтээр гэх мэт шалтгаанууд байна. Нийгмийн ажилтан болон үйлчлүүлэгч аль алинд нь төгсгөлийн шат сэтгэл санааны хувьд амаргүй байдаг. Ахмад настангуудын амьдралд олон салалт хагацал гарч ирэх болсон тул, мөн дасал болсноос ажилтнаас салах нь амаргүй байдаг. Ажилтнуудын хувьд үйлчлүүлэгчтэй дасал болсон, хариуцлагаа орхигдуулж байгаа сэтгэгдэл төрөх гэх мэт шалтгаанаар хэцүү байж болно. Нийгмийн ажилтны зүгээс үйлчилгээ хэзээ дуусах талаар үйлчлүүлэгчид эртнээс мэдэгдэж ойлгуулах, мэдрэмжтэй хандаж тайлбарлах хэрэгцээ гарна. Нийгмийн ажилтан сүүлийн уулзалтан дээр дахин уулзах боломжгүй, ингээд бидний ажлын харилцаа дуусч байгаа гэж үйлчлүүлэгчид хэлэх нь хангалтгүй бөгөөд зохимжтой бус юм. Иймд эртнээс хэзээ нийгмийн ажлын үйлчилгээ дуусгавар

болох тухай мэдээлж үйлчлүүлэгчийг бэлтгэх нь тэдний сэтгэл санааны байдалд эерэг нөлөөтэй байдаг байна.

Дүгнэлт

Би энэ өгүүлэлд ахмад настанд нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэхэд анхаарах арга зүйн асуудлыг тодруулж бичлээ. Ингэхдээ ахмад настанд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний онцлогийг үйлчлүүлэгчтэй тулж ажиллах нийгмийн ажлын практикийн үйл явцын үе шатуудаар тайлбарлахыг хичээсэн юм. Эдгээр нь:

- Үйлчлүүлэгчтэй холбоо тогтоох буюу нийгмийн ажлын үйлчилгээний харилцаа тогтоох
- Асуудлыг тодруулж судлах
- Нөхцөл байдлын үнэлгээ ба үйлчилгээг төлөвлөх
- Нийгмийн ажлын үйлчилгээ интервенц үзүүлэх
- Үйлчилгээг төгсгөх гэсэн үе шатууд бөгөөд ахмад настнуудын биологи, сэтгэл зүй, нийгмийн үүрэг, хүмүүстэй харилцах харилцаа, бие физиологи, эрүүл мэндийн байдал, амьдрал, орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвар зэргээс хамаарч бусад насны үйлчлүүлэгчээс ялгаатай анхаарч үзэх асуудлууд байдаг талаар дээрх үе шат болгоноор авч үзсэн.

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгчийн нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ ашиглахад санаа болгох үүднээс Померой, Холлеран нарын боловсруулсан нийгмийн ажилтан үйлчлүүлэгчээс асууж тодруулах асуултуудын чиглэл, жагсаалтыг дэлгэрэнгүй хэлбэрээр орчуулж орууллаа. Түүнчлэн М.П. Лоутон, И.М. Броди нарын гаргасан “Өндөр настнуудын өдөр тутмын амьдралын ажил үйл гүйцэтгэх чадварын түвшинг тодорхойлох үнэлгээний асуултууд”-ыг нийгмийн ажилтнуудад толилуульж байна.

Эцэст нь, Монгол улсад хүн амд үзүүлэх мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээг бодлогын хувьд болон үйлчилгээг хүргэх бүтэц зохион байгуулалт, механизмын хувьд хөгжүүлэх асуудал чухлаар тавигдаж байгааг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Нийгмийн ажилтнуудын мэргэжил чадварыг дээшлүүлэх, нийгмийн ажлын үйлчилгээний стандарт боловсруулж батлах, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд ашиглах судалгаа шинжилгээний ажилд үндэслэсэн, монгол хүний онцлогийг тусгасан үнэлгээ аргачлал боловсруулах зэрэг олон чиглэлээр хойшлуулахгүй арга хэмжээ авах хэрэгцээ байна.

#### **Ашигласан материал:**

1. Ann Burack-Weiss & Frances Coyle Brennan. Gerontological Social Work Supervision. The Haworth Press, Inc.
2. Cathleen Jordon & Cynthia Franklin. Clinical Assessment for Social Workers: Quantative and Qualitative Methods. 2<sup>nd</sup> Ed. Lyceum Books.Inc. 2003 он.
3. Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар, Өндөр настны ахуй нөхцлийн судалгаа. Улаанбаатар. 2001
4. Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого: Монголын өндөр настангууд. 2000 оны тооллогын дүнд үндэслэн хийсэн сэдэвчилсэн судалгаа. Улаанбаатар. 2002

